**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2021 оны 09 сарын 09 өдөр Дугаар А/559 Улаанбаатар хот

"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг нэгдүгээр, "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан), Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Урологи-Андрологийн төвийн дарга (Д.Баян-Өндөр), Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д тус тус даалгасугай.
3. Тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор тус яамны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан)-т ирүүлэхийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.
4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүр төсөвт тусган ажиллахыг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газарт даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД С.ЭНХБОЛД

141212504

Эрүүл мэндийн сайдын 2021
оны 09 сарын 09 өдрийн А/139 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

# “ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН” АРГА ХЭМЖЭЭГ 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**ЗОРИЛГО:**
Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, дундаж наслалтыг нэмэгдүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ

**ЗОРИЛТ:**

1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого, эрхзүйн орчинг боловсронгуй болгох
2. Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх
3. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, өвчлөл, нас баралтанд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан суурь үзүүлэлтүүдийг тодорхойлон, бодлогын нотолгоо бий болгох

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | Хариуцах байгууллага | Хамтрах Байгуулла-га | Төсөв (сая) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүрэх үр дүн | Хүрэх үр дүн | Хүрэх үр дүн | Хүрэх үр дүн | | | |
| **ЗОРИЛТ 1.** Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого, эрхзүйн орчинг боловсронгуй болгох | | | | | | | | |
| 1.1 | Эрүүл мэндийн салбарын жендэрийн салбар зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах | Салбар зөвлөлийг байгуулсан байна. | Салбар зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулж, тулгамдсан асуудлын хүрээнд тодорхой шийдвэрүүдийг гаргасан байна | | | ЭМЯ | Салбар зөвлөл | ОУБ |
| 1.2 | Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний | Төлөвлөгөө сайдын тушаалаар батлагдсан байна. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна | Төлөвлөгөөний хэрэгжилт 30%-д хүрсэн байна | Төлөвлөгөөний хэрэгжилт 60%-д хүрсэн байна | ЭМЯ | Жендерийн үндэсний хороо (цаашид ЖҮХ) | ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө боловсруулж батлуулах | | | | | | | |
| 1.3 | “Урологи, андрологийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам” боловсруулж, батлуулах | Журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна | Журам сайдын тушаалаар батлагдан, хэрэгжиж эхэлсэн байна. | | | ЭМЯ УНТЭ-ийн Урологи-Андрологийн Төв (цаашид УАТ) | Мэргэжлийн салбар зөвлөл (цаашид МСЗ) | ОУБ |
| 1.4 | “Түрүү булчирхайн хоргүй хавдрын оношлогоо, эмчилгээ” MNS6100:2010 стандартыг шинэчлэх | Стандарт боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан байна | Стандартын төслийг хэлэлцүүлэн, СХЗГ-т хүргүүлсэн байна. | Стандарт батлагдан, хэрэгжиж эхэлсэн байна. | | ЭМЯ УНТЭ-ийн УАТ | Хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллага (цаашид ХХЭМБ) | ОУБ |
| 1.5 | “Бөөрний чулууны оношлогоо, эмчилгээ” MNS6099:2010 стандартыг шинэчлэх | Стандарт боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан байна | Стандартын төслийг хэлэлцүүлэн, СХЗГ-т хүргүүлсэн байна. | Стандарт батлагдан, хэрэгжиж эхэлсэн байна | | ЭМЯ УНТЭ-ийн УАТ | МСЗ | ОУБ |
| 1.6 | “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам” боловсруулан, батлуулах | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинетуудын судалгаа хийгдсэн байна | Журам сайдын тушаалаар батлагдсан байна. | Журмын хэрэгжилт хангагдсан байна. | Журмын хэрэгжилт хангагдсан байна. | ЭМЯ УНТЭ-ийн УАТ | Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар (цаашид АНЭМГ) | ОУБ |
| 1.7 | Онко урологийн оношилгоо, эмчилгээний удирдамж боловсруулах | Удирдамжийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна | Удирдамж сайдын тушаалаар батлагдсан байна. | Удирдамжийн хэрэгжилтийг хангасан байна | Онко урологийн тусламж, үйлчилгээ иргэдэд хүрсэн байна | ЭМЯ ХСҮТ | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд АНЭМГ | ОУБ |
| 1.8 | Эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн | | Ажлын байрны үлгэрчилсэн | Ажлын байрны тодорхойлтыг | Үйл ажиллагаанд | ЭМЯ УНТЭ-ийн УАТ | АНЭМГ МСЗ ХХЭМБ | ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын байрны тодорхойлт батлуулах | | зураглал гарсан байна. | батлуулсан байна | мөрдлөг болгосон байна | | | |
| 1.9 | Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, кабинет байгуулах үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлж, шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах | Эрэгтэйчүүдийн кабинет байгуулахад шаардагдах төсвийн тооцоолол гаргасан байна | Улсын төсөвт суулгах үндэслэл боловсруулсан байна | Үйл ажиллагааг төлөвлөх төсвийг батлуулан, 2 дүүрэг, 2 аймагт кабинет байгуулсан байна | Төвийн 4 дүүрэг, 6 аймагт кабинет байгуулсан байна | ЭМЯ Сангийн яам | МСЗ АНЭМГ НЭМҮТ | Улсын төсөв 5.0 |
| 1.10 | Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад санал өгөх | | Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг байгуулах | Хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулах | Хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах | ЭМЯ | ХНХЯ ХЗДХЯ | ОУБ |

**ЗОРИЛТ 2.**
Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Өсвөр насны хөвгүүдийн тулгамдсан асуудлыг сонсох, хувь хүний нууцлалыг хадгалах, хамтран ярилцах, зөвлөгөө өгөх цахим хуудас, итгэлтэй утас ажиллуулах | Өсвөр насны эрэгтэй хүүхдүүдэд зориулсан мэдээлэл боловсруулсан байна. | Цахимаар харилцах, зөвлөгөө өгөх хаяг, итгэлтэй утас тогтмол ажилладаг болсон байна | Цахимаар хандсан өсвөр насны эрэгтэй хүүхдийн хандалтын тоо нэмэгдэж, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг тухай бүр нь авсан байна | | НЭМҮТ ЭХЭМҮТ СЭМҮТ | ЕБС ОУБ | Улсын төсөв 10.0 |
| 2.2 | Өсвөр насны эрэгтэй хүүхдийн нөхөн үржихүй, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, осол, гэмтлээс сэргийлэх МСС олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол хийх | Өсвөр насны эрэгтэй хүүхдэд зориулсан цуврал контент хийсэн байна. | МСС цувралаар тогтмол зохион байгуулсан байна. | Эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх МСС нэмэгдсэн байна. | Зорилтот бүлэгт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийгдсэн байна. | ЭМЯ НЭМҮТ ГССҮТ НЭМҮТ ЭХЭМҮТ | АНЭМГ ОУБ ТББ-ууд | Улсын төсөв 10.0 |
| 2.3 | Өсвөр насны хүүхдийг сургуулийн орчинд үйлдэгдэх хүчирхийллээс сэргийлэх зөвлөмж, гарын авлага бэлтгэх | Зөвлөмж, гарын авлагын төсөл боловсруулсан байна. | Гарын авлага хэвлэгдэн зорилтот бүлэгт хүрсэн байна | Сургуулийн орчинд үйлдэгдэх хүчирхийлэлээс сэргийлэх арга хэмжээ зохион байгуулагдсан байна | | НЭМҮТ СЭМҮТ | БШУЯ АНЭМГ | Улсын төсөв 5.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн сургагч бэлтгэх сургалтыг өргөжүүлэн, эрэгтэй хүүхдүүдэд чиглэсэн гарын авлага боловсруулах | | Сургалтын удирдамж хөтөлбөр батлагдсан байна.<br>Гарын авлагын материалын төсөл боловсруулсан байна | Сургалт зохион байгуулагдсан байна.<br>Гарын авлагын материал боловсруулан, хэвлүүлсэн байна | Сургалт зохион байгуулагдсан байна. | ЭМЯ<br>НЭМҮТ<br>ЭХЭМҮТ | АНЭМГ<br>ТББ-ууд | Улсын төсөв<br><br>15.0 |
| 2.5 | Жил бүр "Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян"-ны үйл ажиллагааг зохион байгуулах | Батлагдсан удирдамжийн дагуу аян зохион байгуулсан байна. | Батлагдсан удирдамжийн дагуу аян зохион байгуулсан байна | Батлагдсан удирдамжийн дагуу аян зохион байгуулсан байна | Батлагдсан удирдамжийн дагуу аян зохион байгуулсан байна | ЭМЯ<br>БШУЯ<br>НЭМҮТ | АНЭМГ<br>Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар | Улсын төсөв<br><br>100.0 |
| 2.6 | Эрэгтэйчүүдийг эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлтээр сурталчилгаа хийгдсэн байна | Эрэгтэйчүүдийн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь нэмэгдсэн байна. | Эрэгтэйчүүдийн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь нэмэгдсэн байна. | Эрэгтэйчүүдийн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь нэмэгдсэн байна. | НЭМҮТ | ХНХЯ<br>Аймаг, нийслэлийн ЗДТГ<br>ЖҮХ | Улсын төсөв<br><br>10.0 |
| 2.7 | "Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоо" арга хэмжээ зохион байгуулах | | Зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөө гарсан байна. | Үйл ажиллагааны тайлан бичигдсэн байна | Үйл ажиллагааны тайлан бичигдсэн байна | НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЗДТГ<br>АНЭМГ<br>ТББ-ууд | Улсын төсөв<br><br>50.0 |
| 2.8 | "Гүзээгүй Монгол эр хүн" үндэсний аян зохион байгуулах | | Аяны удирдамж, төлөвлөгөө батлагдсан байна.<br><br>МСС хийгдсэн байна. | Хамрагдсан эрчүүдийн тоо нэмэгдсэн байна | Хамрагдсан эрчүүдийн тоо нэмэгдсэн байна | НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЗДТГ<br>АНЭМГ<br>Хэвлэл мэдээлэл ТББ-ууд | Улсын төсөв<br><br>50.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.9 | Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагч, цэрэг, сонсогчдод нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол хийж, хамтран ажиллах | | Эрэгтэйчүүдэд зориулсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалтын агуулга бэлтгэгдсэн байна. | Ухуулга, нөлөөллийн уулзалт, сургалт, сурталчилгаа хийгдсан байна | Ухуулга, нөлөөллийн уулзалт, сургалт, сурталчилгаа хийгдсан байна | НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ ААН ТББ-ууд | Улсын төсөв 20.0 |
| 2.10 | Цэрэг арми, батлан хамгаалах, хил хамгаалах, уул уурхай, барилга, зам тээврийн чиглэлээр ажиллаж буй компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах цахим болон танхимын сургалт явуулах | Ухуулга нөлөөллийн баримтын цомогийн төсөл боловсруулсан байна | Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, үйл ажиллагааны тайлан | Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, үйл ажиллагааны тайлан | Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, үйл ажиллагааны тайлан | ЭМЯ СЭМҮТ | ДЭМБ УУЯ БХБЯ ЗТЯ ТББ-ууд | Улсын төсөв 20.0 |
| 2.11 | Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл, жирэмслэлтээс сэргийлэх байнгын арга болох эрэгтэйн үрийн суваг боох мэс ажилбарын талаар таниулах, (вазэктоми) бэлгэвчийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр жендэрийн мэдрэмжтэй МСС хийх | Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэлийн сурталчилгааны материал боловсруулсан байна. | Сурталчилгааны материал хэвлэгдсэн байна. ЖСАХ болох бэлгэвчний талаар компанит ажлууд өрнүүлсэн байна | ЖСАХ болох бэлгэвчний талаар компанит ажлууд өрнүүлсэн байна | ЖСАХ болох бэлгэвчний талаар компанит ажлууд өрнүүлсэн байна | НЭМҮТ | ТББ, НҮБХАС, НҮБХС ЖҮХ | Улсын төсөв 60.0 |
| 2.12 | Архинаас гарч, эрүүл амьдралын хэв маягийг сонгосон эрэгтэйчүүдийг дэмжих (НА, АА болон өөртөө туслах бүлэг) сайн | | НА, АА болон өөртөө туслах бүлгийг дэмжин, төсөл хөтөлбөрт хамруулсан байна. | Сайн дурын төвүүд нэмэгдсэн байна. | Үйл ажиллагааны тайлан гарч, үр дүнг тооцсон байна | НЭМҮТ СЭМҮТ | ХХНЯ БШУЯ ТББ-ууд | Улсын төсөв 100.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дурын төв нээх, ТББ-ыг дэмжих | | | | | | | |
| 2.13 | Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагч, цэрэг, сонсогчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр салбар хооронд аян зохион байгуулах | Аян зохион байгуулах удирдамжийн төсөл боловсруулсан байна. | Салбар хооронд аян зохион байгуулах аяны удирдамж батлаж хүргүүлсэн байна. | Аяныг тогтмол зохион байгуулж, манлайлсан байгууллага хамт олныг урамшуулж, олон нийтэд сурталчилсан байна. | Аяны үр дүнг тооцож, хэлэлцсэн байна. | БХЯ УУХҮЯ ЗТХЯ | ЭМЯ НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ ЖҮХ | Улсын төсөв 100.0 |
| 2.14 | Жолооч нарын эрүүл мэндэд онцгойлон анхаарч ажилласан байгууллагыг олон нийтэд мэдээллэх, сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах | | Сайн туршлагын удирдамж батлагдсан байна. Холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | Сайн туршлагыг олон нийтэд сурталчилсан байна. | Сайн туршлагыг олон нийтэд сурталчилсан байна. | ЭМЯ ЗТХЯ ЦЕГ | НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ ЖҮХ | Улсын төсөв 10.0 |
| 2.15 | Малчин эрэгтэйчүүдэд чиглэсэн амьдралын зөв дадал бий болгох, эрүүл урт наслах зан үйлийг хэвшил болгох зорилтот аян өрнүүлэх | Аян зохион байгуулах талаар холбогдох байгууллагатай уулзалт зохион байгуулсан байна | Аян зохион байгуулах удирдамж батлаж, холбогдох газруудад хүргүүлсэн байна. | Аяныг тогтмол зохион байгуулж, манлайлсан аймгийг урамшуулах | Аяны үр дүнг тооцож, хэлэлцсэн байна. | ЭМЯ ХХААХҮЯ | Аймаг, нийслэлийн ЗДТГ | Улсын төсөв 50.0 |
| 2.16 | Уул уурхай, дэд бүтцийн салбарт ажилладаг эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах | | Сургалтын удирдамж, хөтөлбөр бэлэн болсон байна. | 4-5 байгууллагад сургалт зохион байгуулсан байна. | 4-5 байгууллагад сургалт зохион байгуулсан байна. | УУХҮЯ | ХНХЯ ЗТХЯ ЭМЯ | ОУБ |
| 2.17 | ҮБХИС, ДХИС-ийн сургалтын хөтөлбөрт эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар багц | | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар багц цагийн | ҮБХИС, ДХИС-ийн сургалтын агуулгад эрэгтэйчүүдийн | Хугацаат цэргийн алба хаагчдад эрэгтэйчүүдийн | БХЯ | БШУЯ НЭМҮТ | ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | цагийн сургалтын хөтөлбөр оруулж, төгсөгчдөөр дамжуулан хугацаат цэргийн алба хаагчдад эрүүл мэндийн боловсрол олгох | | сургалтын үндэслэл бэлэн болсон байна | эрүүл мэндийн талаар багц цагийн сургалтын хөтөлбөр тусгагдсан байна. | эрүүл мэндийн боловсрол олгож эхлэнэ | | | |
| **ЗОРИЛТ 3.**<br>Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | | | | | | | | |
| 3.1 | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд эрэгтэйчүүдийн кабинетын (урологи, андрологи) тусламж, үйлчилгээг үзүүлдэг болсон байх | Урологи, андрологийн тусламж, үйлчилгээний байдалд үнэлгээ хийсэн байна. | Урологи, андрологийн тусламж үйлчилгээг 2-4 эмнэлэгт үзүүлдэг болсон байна. | Урологи, андрологийн тусламж үйлчилгээг 5-6 эмнэлэгт үзүүлдэг болсон байна. | Урологи, андрологийн тусламж үйлчилгээг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд үзүүлдэг болсон байна. | ЭМЯ<br>УГТЭ<br>УАТ | МСЗ<br>ОУБ-ууд | Улсын төсөв<br>300.0<br>/ОУБ/ |
| 3.2 | Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетыг (урологи, андрологи) байгуулах | | Эрэгтэйчүүдийн кабинетыг 1-2 эмнэлэгт байгуулсан байна | Эрэгтэйчүүдийн кабинетыг 3-4 эмнэлэгт байгуулсан байна | Эрэгтэйчүүдийн кабинетыг 5-6 эмнэлэгт байгуулсан байна | ЭМЯ<br>УГТЭ<br>УАТ | Аймаг, нийслэлийн ЗДТГ<br>АНЭМГ<br>МСЗ | |
| 3.3 | Онко урологийн оношилгоо, эмчилгээг олон улсын жишигт хүргэж, дурангийн мэс заслыг нэвтрүүлэх | | Тоног төхөөрөмжөөр хангасан байна | Оношилгоо, эмчилгээний удирдамжийг баталсан байна. | Онко-урологийн оношилгоо, эмчилгээний төрөл нэмэгдсэн байна. | ЭМЯ<br>ХСҮТ | УНТЭ<br>АНЭМГ | ОУБ |
| 3.4 | Эрэгтэйчүүдийн үйргүйдлийн чиглэлээр тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн байх | | Эрэгтэйчүүдийн үргүйдлийн тусламж, үйлчилгээнд үнэлгээг хийсэн байна. | 1-2 эмнэлэгт үргүйдлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна. | 2-3 эмнэлэгт үргүйдлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна. | ЭМЯ<br>ЭХЭМҮТ<br>УАТ | АНЭМГ<br>МСЗ | Улсын төсөв<br>100.0<br>/ОУБ/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Төгсөлтийн дараах сургалтаар андрологийн төрөлжсөн мэргэшлийн эмчийг үе шаттайгаар бэлтгэх | Андорологийн мэргэшил эзэмшсэн эмчийн тоо | Мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан эмчийн тоо | Мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан эмчийн тоо | Мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан эмчийн тоо | ЭМЯ ЭМХТ | АШУҮИС АНЭМГ | Улсын төсөв 50.0 |
| 3.6 | Урологи, андрологийн мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтанд орон нутгийн эмч нарыг үе шаттайгаар хамруулах, сургах | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, гарын авлага гаргасан байна | 10 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | ЭМЯ МСЗ | Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ ОУБ-ууд | Улсын төсөв 50.0 |
| 3.7 | Сэтгэцийн эмч нарын дунд эрэгтэйчүүд, хөвгүүдэд зориулсан зөвлөгөө өгөх ур чадварын сургалт зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, гарын авлага гаргасан байна | 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | ЭМЯ СЭМҮТ | ЭХЭМҮТ АНЭМГ ОУБ-ууд | Улсын төсөв 50.0 |
| 3.8 | Өсвөр үеийн эмч, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх ур чадварт сургах | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, гарын авлага гаргасан байна | 50 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | ЭМЯ НЭМҮТ СЭМҮТ | БШУЯ АНЭМГ | Улсын төсөв 70.0 |
| 3.9 | Хөгжлийн бэрхшээлтэй хөвгүүд, эрэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэхэд хүний нөөцийг чадавхижуулах | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, гарын авлага гаргасан байна | 10 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | 10 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | ЭМЯ НЭМҮТ СЭМҮТ | ХНХЯ, ХБХХЕГ ЭМХТ АНЭМГ | Улсын төсөв 50.0 |
| 3.10 | Эмч, мэргэжилтнүүдийн дунд ЛГБТИ хүмүүсийн талаарх мэдлэг, мэдээллийг нь сайжруулан, сэтгэлзүйн | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, | 50 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | 50 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | ЭМЯ СЭМҮТ | НЭМҮТ Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай | Улсын төсөв 50.0 /ОУБ/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тусламж үзүүлэх ур чадварт сургах | боловсруулсан байна | гарын авлага гаргасан байна | | | | мэргэжлийн төвүүд АНЭМГ | |
| 3.11 | Эрчүүдийн даавар, дотоод шүүрлийн чиглэлээр эмч, мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтанд хамруулах | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, гарын авлага гаргасан байна | 10 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | 10 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | ЭМЯ ЭМХТ | ЭХЭМҮТ АНЭМГ | Улсын төсөв 50.0 |
| 3.12 | Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын эмч, мэргэжилтэнг эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө өгөх ур чадварт сургах | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, гарын авлага гаргасан байна | 10 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулж, гарын авлагаар хангасан. | БХЯ | ЭМЯ НЭМҮТ АНЭМГ ЖҮХ | Улсын төсөв 50.0 |
| **ЗОРИЛТ 4.**<br>Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, өвчлөл, нас баралтанд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлан суурь үзүүлэлтүүдийг тодорхойлон, бодлогын нотолгоо бий болгох | | | | | | | | |
| 4.1 | Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн Дэлхийн судалгаа зохион байгуулах /GSBSHS/ | Судалгаа зохион байгуулах талаар ОУБ-тай уулзалт зохион байгуулсан байна. | Судалгааны арга батлуулсан байна. Судалгаа зохион байгуулах бэлтгэл хангагдсан байна. | Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагдсан байна. | Судалгааны эцсийн тайлан гарсан байна. Судалгааны дүнг танилцуулсан байна. | НЭМҮТ СЭМҮТ | НЭМҮТ ЭХЭМҮТ АНЭМГ | ОУБ |
| 4.2 | Өсвөр насны хүүхдийн төлөвшил, сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй нийгмийн сүлжээ, ТВ сурталчилгаа, мэдээ мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх | Судалгааны арга, аргачлал боловсруулан байна. | Арга, аргачлалаа батлуулан, судалгааны мэдээ материал цуглуулсан байна. | Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагдсан байна. | Судалгааны эцсийн тайлан гарсан байна. Судалгааны дүнг танилцуулсан байна. | СЭМҮТ АШУҮИС | НЭМҮТ ЭХЭМҮТ АНЭМГ | Улсын төсөв 10.0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3 | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт, нас баралтын шалтгаанд дүн шинжилгээ хийх | | Мэдээлэлд дүн шинжилгээ хийгдсэн байна. | Дүн шинжилгээний үр дүн гарч, танилцуулагд-сан байна. | Судалгааны үр дүнг холбогдох газруудад танилцуулсан байна. | ЭМХТ АШУҮИС | НЭМҮТ | Улсын төсөв 10.0 |
| 4.4 | Эрэгтэйчүүдийн үргүйдлийн шалтгаанд судалгаа хийх | Судалгааны арга, аргачлал боловсруулан байна. | Судалгааны арга, аргачлал батлуулан, мэдээ материал цуглуулсан байна. | Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагд-сан байна. | Судалгааны эцсийн тайлан гарсан байна. Судалгааны дүнг танилцуулсан байна. | ЭХЭМҮТ ЭМХТ | НЭМҮТ АШУҮИС ЖҮХ | Улсын төсөв 20.0 |
| 4.5 | ЛГБТИ хүмүүсийн дунд судалгаа явуулан, тэдэнд тулгарч буй бэршээлийг гаргах | Судалгааны арга, аргачлал боловсруулан байна. | Судалгааны арга, аргачлал батлуулан, мэдээ материал цуглуулсан байна. | Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагд-сан байна. | Судалгааны эцсийн тайлан гарсан байна. | ХӨСҮТ СЭМҮТ | НЭМҮТ АШУҮИС | Улсын төсөв 5.0 |
| 4.6 | Хүүхэд, залуусын архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээнд хяналт, шалгалт тогтмол зохион байгуулах | | Хяналт шалгалт хийх удирдамж батлагдсан байна. | Хяналт, шалгалт хийгдэж, дүнг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | Хяналт, шалгалт хийгдэж, үр дүнг түгээсэн байна. | МХЕГ ЦЕГ | НЭМҮТ СЭМҮТ | Улсын төсөв 10.0 |
| 4.7 | Арга хэмжээний хэрэгжилтйн явцын болон төгсгөлийн үнэлгээ хийх | | Үнэлгээний ажлын хэсэг байгуулан, явцын үнэлгээ хийсэн байна | Үнэлгээний дүнг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | Үнэлгээний ажлын хэсэг байгуулан, төгсгөлийн үнэлгээ хийсэн байна | МСЗ АШУҮИС | НЭМҮТ ЭМХТ АНЭМГ | Улсын төсөв 10.0 |

--- oOo ---

Эрүүл мэндийн сайдын 2021
оны 09 сарын 09 өдрийн A/559 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

## “ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2019, 2020 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашигласан.

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин (оноор) | | | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2021 | 2022 | 2023 | |
| **I. Эрсдэлт хүчин зүйлийн үзүүлэлт /эрэгтэйчүүдэд/** | | | | | | | |
| 1 | Согтууруулах ундааны хэрэглээний хувь /сүүлийн 1 сард/* | Хувь | 34.8 | 34.6 | 34.1 | 33.6 | - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br>- Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| | Нийт хүн амын тамхидалтын түвшин* | Хувь | 24.2 | 24.1 | 23.6 | 23.1 | |
| | Илүүдэл жин ба таргалалттай хүмүүсийн эзлэх хувь* | Хувь | 49.4 | 49.2 | 48.7 | 48.2 | |
| **II. Нас баралтын үзүүлэлт /эрэгтэйчүүдэд/** | | | | | | | |
| 2 | Зүрхний шигдээс өвчнөөс шалтгаалсан нас баралтын түвшин /10000 хүн амд/** | Хувь | 8.5 | 8.0 | 7.5 | 7.0 | - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br>- Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| | Элэгний хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин /10000 хүн амд/** | Тоо | 5.5 | 5.2 | 4.8 | 4.3 | |
| | Осол гэмтэл, гадны шалтгааны улмаас нас барсан тохиолдол /10000 хүн амд/** | Тоо | 13.5 | 13.3 | 12.8 | 12.3 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **III. Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт** | | | | | | | |
| 3 | Зонхилон тохиолдох амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчний эрт илрүүлэг үзлэгт эрэгтэйчүүдийн хамрагдсан хувь*** | Хувь | 41.5 | 42.5 | 45.0 | 48.5 | - Улсын нэгдсэн төв эмнэлгийн Урологи-Андрологийн Төв<br>- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв |
| | Эрэгтэйчүүдийн эмчийн (урологи, андрологи) тоо | Тоо | Урологи 57<br>Андрологи 15 | Урологи 60<br>Андрологи 18 | Урологи 70<br>Андрологи 28 | Урологи 80<br>Андрологи 38 | |
| | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетын (урологи, андрологи) тоо | Тоо | 12 | 14 | 18 | 24 | |

**Тайлбар: Мэдээллийн эх үүсвэр**

**Халдварт бус өвчин, осол гэмтэлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн тархалтын үндэсний IY судалгаа 2019 он*

*** Эрүүл мэндийн үзүүлэлт, Хавдар судлалын үндэсний төвийн статистик үзүүлэлт 2020 он*

**** Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2020 он*

***** Эрүүл мэндийн мэдээлэл, сарын мэдээлэл, 2020 он*

--- oOo ---